

**Хөгжлийн Шийдэл ТББ**

Tel : +976 77 22 4008  
Fax : +976 77 22 4001  
E-mail : tor@dsmongolia.org  
Web : www.dsmongolia.org



**Development Solutions NGO**

No.19, Building 32, 3rd Khoroo  
Peace Avenue, Bayanzurkh District  
P.O.Box-1684, Central Post Office  
Ulaanbaatar-13, Mongolia 15160

**ВИДЕО ШТОРК ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ**

**Хугацаа: Үнийн саналыг 2021 оны 09 дүгээр сарын 20-ны 17:00 цаг хүртэл хүлээн авна.**

Америкийн Нэгдсэн Улсын Олон Улсын Хөгжлийн агентлаг (ОУХА)-ийн санхүүжилтээр Хөгжлийн Шийдэл ТББ-ын хэрэгжүүлж буй “BEST хөтөлбөр”-ийн Хурдасгуур хөтөлбөрийн хүрээнд Pitching хийх арга техникийг харуулсан видео шторк хийх эрх бүхий байгууллагуудыг сонгон шалгаруулалтад оролцох сонирхлоо илэрхийлж, материалаа ирүүлэхийг урьж байна.

## 1. ТАНИЛЦУУЛГА

Хөгжлийн Шийдэл ТББ нь Америкийн Нэгдсэн Улсын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн санхүүжилттэй **Бизнесийн Тогтвортой Хөгжлийг Дэмжих, Ил Тод Байдлыг Нэмэгдүүлэх Хөтөлбөр (BEST хөтөлбөр)-ийг** Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Дорноговь, Дорнод, Завхан, Ховд, Өвөрхангай, Хэнтий, Өмнөговь, Баянхонгор болон Хөвсгөл аймагт 2019 оны 12 дугаар сарын 02-ноос 2024 оны 12 дугаар сарын 01-ний хооронд хэрэгжүүлнэ.

### Бичил Санхүүжилтийн Тэтгэлэгт Хөтөлбөр:

BEST хөтөлбөр нь Зорилт 5 буюу “Цаашид тогтвортой хөгжих боломжтой хэдий ч, санхүүжилт авах боломжгүй ТББ, гарааны болон жижиг бизнес эрхлэгчдэд ичил санхүүжилт олгох” зорилтын хүрээнд Бичил Санхүүжилтийн Тэтгэлэгт Хөтөлбөрийг хоёр дахь жилээсээ буюу 2020 оны 12 сараас эхлэн 2024 оны 12 сар хүртэл дөрвөн жилийн хугацаатай хэрэгжүүлнэ. Энэхүү тэтгэлэгт хөтөлбөрт цаашид тогтвортой хөгжих хэдий ч банк болон банк бус санхүүгийн байгууллагаас зээл, санхүүжилт авах боломжгүй ЖДБ болон гарааны бизнес эрхлэгчид мөн ЖДБ-ийг дэмжих зорилго бүхий төрийн сангуудыг ил тод, нээлттэй болгоход чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг ТББ-д хамрагдах боломжтой. Нэг байгууллагад олгогдох тэтгэлгийн хэмжээ 10,000,000 (арван сая) төгрөг хүртэл байна.

## 2. ВИДЕО ШТОРКИЙН ЗОРИЛГО

BEST хөтөлбөрийн Зорилт 5 - Хурдасгуур хөтөлбөрийн хүрээнд тэтгэлэг горилогч нарт ордог Pitching буюу Төслийн найрааны сургалтыг илүү үр дүнтэй шинэлэг аргаар орох боломжийг бүрдүүлэх зорилготой. Тус видео шторк нь амжилттай Pitching хийж буй бодит жишээ болон Pitching-ийн бүтцийг тодорхой системтэй байдлаар задалж харуулах юм. Ингэснээр тэтгэлэг горилогч нар эцсийн сонгон шалгаруулалтын үеэр хэрхэн зөв арга техник, бүтцийн хүрээнд өөрийн төслөө хэрхэн хөрөнгө оруулагчдад амжилттай танилцуулах вэ гэдгийг суралцаж мэдэх боломж бүрдэх юм.

## 3. АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ

Видео нэвтрүүлэг хийх байгууллага нь дараах ажил үүргийг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

Ажил үүргийн агуулга	Шалгуур үзүүлэлт хэмжүүр	Огноо
Зохиол	Захиалагчаас хүргүүлсэн зохиолтой танилцаж, бичлэгийн титерийг бэлдэх	2021.10.04
Санал авах	Захиалагчаас титер дээр санал авах	2021.10.07
Танилцуулах	Эхний байдлаар видео бичлэгийг захиалагчид танилцуулах	2021.10.18
Эцсийн бүтээгдэхүүн	Захиалагчаас өөр санал байвал засвар оруулна. Санал байхгүй бол хадмал Англи орчуулгатай болон дохионы хэлний орчуулгатай бичлэгийг хүлээлгэн өгөх	2021.10.25

#### 4. ВИДЕОНД ТАВИГДАХ ШААРДЛАГУУД

- Нийт 8 минут орчмын хугацаатай видео бичлэг байх;
- Видеоны ажлыг санал хүсэлтийн үндсэн дээр нэмэлт төлбөргүйгээр засвар оруулж өгөх;
- Видеоны ажлуудад ашигласан зүйлс нь бусдын оюуны өмчийг хууль бусаар ашиглаагүй байх;
- Элдэв дуу шуум орохгүй, стандартад нийцсэн микрофон ашиглаж цэвэрхэн дуугаралттай байх;
- Дүрсны өндөр чанартай, нягтаршил сайтай байх;
- Гэрэлтүүлэлт, бичлэгийн орчин сайн байх;
- Видеог англи subtitle-тай, дохионы хэлний орчуулгатайгаар хүлээлгэн өгөх;
- Тухайн бичлэгт орж байгаа хүн өөрийнхөөрөө, тайван, чөлөөтэй ярьсан байх;
- 3D, 2D creative/ бүтээлч хэв маягтай байх.

#### 5. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Нэр	Тодорхойлолт
Ижил төстэй ажлын туршлага	Ижил төрлийн creative видео шторк хийж гүйцэтгэж байсан ажлын туршлагатай байх
Зураг авалт хийх хүний нөөц	Видео шторкийг хариуцаж ажиллах хүний нөөцийн туршлага
Зураг авалт хийх тоног төхөөрөмж	Дуу дүрсний өндөр чанар үзүүлэлт бүхий тоног төхөөрөмжтэй байх, гэрэлтүүлэлтийн төхөөрөмжтэй байх

*Анхааруулга: Талууд харилцан зөвшилцсөний үндсэн дээр ерөнхий агуулга, ажлын хүрээнд зарим нэг өөрчлөлтийг энэхүү удирдамжид оруулж болно.*

#### 6. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН

- а. Видео шторкийг чанарын өндөр түвшинд, захиалагчийн шаардлагад нийцүүлэн бэлэн болгосон байх.

#### 7. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА

Ажил гүйцэтгэх хугацаа: 2021.09.24-2021.10.25 хүртэл

#### 8. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Зөвлөх үйлчилгээний төлбөр тооцоо Сангийн сайдын 86-р тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжигдэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-ын дагуу зохицуулагдана.

## **9. БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ**

- a. Санхүүгийн дэлгэрэнгүй санал (НӨАТ-гүй үнэ салангид файлаар илгээсэн байх);
- b. Байгууллагын танилцуулга;
- c. Ижил төстэй хийж байсан видеоны ажлууд (салангид файлаар илгээх эсвэл үзэх боломжтой линкийг илгээсэн байх);
- d. Видеоны ажлыг хариуцаж ажиллах хүмүүсийн намтар CV;
- e. Тоног төхөөрөмжийн жагсаалт.

Сонирхсон байгууллагууд **Монгол** хэлээр бэлтгэсэн материалаа **2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 17:00 цагаас өмнө** дор дурдсан и-мейл хаягаар ирүүлнэ үү.

**И-мейл хаяг:**

**[myagmartsermaa@dsmongolia.org](mailto:myagmartsermaa@dsmongolia.org)**

**Утас: 9552-6668**